

Д.ГОТОВ

**Холбооны яамны сайд асан,
Монгол улсын гавъяат холбоочин**

*Харилцаа холбооны байгууллага
үүсч хөгжсөний 95 жилийн ойд*

Харилцаа холбооны салбарын эрчимтэй хөгжил, бүтээн бөйгуулалтын он жилүүд

1.Өмнө хэлэх цөөн үг

Өргөн уудам нутагтай, хүн ам сийрэг, морин өртөөнөөс өөр дэд бүтэцгүй, хэвлэл, мэдээлэл дамжуулах систем хөгжөөгүй манай улсын хувьд нам төрийн бодлого зорилтыг ард иргэддээ шуурхай хүргэхэд радио , шуудан, харилцаа холбооны ач холбогдол онцгой чухал болохыг МАН соргоогоор мэдэрч харилцаа холбоог бүхэлд нь хөгжүүлэх асуудлыг цаг алдалгүй шийдвэрлэхийн төлөө өөрийн орны санхүү эдийн засгийн боломжоо түшиглэн зохих арга хэмжээг дэс дараатай авч эхэлсэн билээ.

1923 оны 7-р сард эхэлсэн МАН-ын 2-р их хурлын тайлан илтгэлд ” хол ойрыг холбож, хэл мэдээ авалцахад хэрэглэх төмөр утас телефон ховор, захиа авалцах шуудангийн өртөөгүй, иймийн харгайгаар уналга мал тэрэг, чарга хүний бие хичнээн үрэгдэж сүйдэхээс гадна, хичнээн өдөр сар гээгдэж буй нь жил бүр 3-4 сая лан хий хаягдаж байгаа нь илт ажгуу. Тиймийн тулд...олон газрын нэвтрэлцэх хэргийг хүндэтгэн үзэж ... төмөр утас татаж, шуудангийн өртөө хэдэн газар тогтоох мэтээр арвилах ,хурдатгах явдлыг хичээвэл зохимой” хэмээн заасан байлаа. Түүхэн товчоо 96. Бас XX зууны эхэнд радио өргөн нэвтрүүлэг үүсч түүнийг дэлхийн олон улс эрчимтэй ашиглаж эхэлсэн учир 1927 онд хуралдсан МАХН-ын 6-р их хурал "агаарын сонсох мэдээ хэрэглэх явдлын тухай хэргийг бодолхийлэн оролдвоос зохино”188 хэмээн тэмдэглэж, тус хурлаас гаргасан тогтоолдоо радиог байгуулах эдийн засгийн асуудалд анхаарч "Басхүү агаарын сонсох мэдээг хэрэглах явдлыг орлого, зарлагад харьцуулан гүйцэтгэхийг хичээвэл зохино" гэж заасан нь манай оронд радиогийн ач тус юу юунаас ил ужал байсныг илтгэн харуулж байлаа. Энэхүү дээрх том зорилтуудыг манай улс дан ганц өөрийн хүч

хөрөнгөөр шийдвэрлэх боломж үнэхээр байгаагүй учраас хойт хөрш Зөвлөлт засгийн газарт хандахаас ~~байсан~~ тэр үед Намын төв хороо зохих шугамаар уг асуудлыг тавьсны хариуд Зөвлөлтийн зүгээс хүсэлтийг хүлээн авч шаардлагатай арга хэмжээ авч дэмжиж туслахад бэлэн байгаагаа илэрхийлж байсан түүхэн баримт байдаг юм. Зөвлөлт холбоот улсын техник эдийн засаг болон мэргэжилтнүүдйн шууд дэмжлэг тусламжтайгаар эхний ээлжинд Богд хаант засгийн үед ажиллуулж байсан техник төхөөрөмж, Зөвлөлт засгийн газраас манайд үнэ төлбөргүй шилжүүлсэн тоног төхөөрөмж, шугамын хэвийн ажиллагааг хангах монгол мэргэжилтэн дагалдуулан сургах, баруун, зүүн алсын аймгуудад радио-телефон болон цахилгаан мэдээ-телеграфын холбооны шугам байгуулах, нийслэл хотод бага чадлын радио нэвтрүүлэх станцыг хүлээн авах станцын хамт байгуулах, мөн нийслэл хотын гар телефон залгуурын багтаамжийг нэмэгдүүлэх замаар албан газруудыг утсан харилцаатай болгох, улмаар аймгуудын төвд гар телефон-залгуур тавих зэрэг арга хэмжээнүүдийг дэс дараатай хэрэгжүүлж эхний ээлжинд төрийн байгууллага, аж ахуйн нэгж, албан газруудын харилцаа дамжуулах боломжийг бүрдүүлсэн бөгөөд хөгжлийн эхний шатны эдгээр арга хэмжээнүүд нь 1925- 1960 онуудад тасралтгүй үргэлжилсэн шилжилтийн үе байсан юм.

2. Эрчимтэй хөгжөл, бүтээн байгуулалт.

Харилцаа холбооны салбарын эрчимтэй хөгжил нь МАХН-ын Төв Хорооны Улс төрийн товчоо 1956 оны 10 дугаар сарын 23-нд “Орон нутгийг радиожуулах ба хүн амыг радиогоор үйлчлэх... тухай” тогтоол гаргаж, 1957-1970 онд радио өргөн нэвтрүүлэг болон харилцаа холбоог хөгжүүлэх хэтийн төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэхийг Холбооны яамны сайд Л.Дамдинжав-т даалгасан тэр үеэс эхэлсэн бөгөөд 1965 онд Холбооны яам дахин байгуулагдснаар хүчээ авсан түүхтэй. . Ерөнхий төлөвлөгөө боловсруулах, түүнийг хэрэгжүүлэх ажил бараг нэгэн зэрэг явагдаж асар богино хугацаанд бүрэн шийдвэрлэгдсэн болох нь түүхэн үйл явцаар батлагдсан бөгөөд ЗХУ-ын тал шаардагдах тоног төхөөрөмжийг төсөлд заасны дагуу хүрэлцэх хэмжээгээр нь манайд нийлүүлсний зэрэгцээ угсрах суурьлуулахад тусалцаа үзүүлснээр хэрэгжүүлэх арга хэмжээ төлөвлөсөн цаг

хугацаандаа биелсэн байна. Ерөнхий схем-төлөвлөгөө батлагдаж байх үед Монгол улсын эдийн засаг, аж ахуй соёлыг хөгжүүлэх гурван /1958-1960/ жилийн төлөвлөгөө зохиох ажил ид явагдаж аймаг сумдын радиожуулалт, Хонхорын радио нэвтрүүлэх төв, Улаанбаатар хотын холбооны иж бүрэн үйлчилгээний шинэ барилга барих асуудлууд төлөвлөгөөнд бүрэн хэмжээгээр тусгасан байлаа. Радио нэвтрүүлэх төвийн бүрэлдэхүүнд урт долгионы 150 квт-ын чадалтай 1 станц, богино долгионы 50, 25, 5 квт-ын чадалтай нэвтрүүлэгч станц хэд хэдийг тавих болон Наран дахь радио хүлээн авах станцыг өргөтгөх, тэдгээрийг холбосон тусгай физик кабель татах мөн хоёр станцын ажилчдын орон сууц барих ажлуудыг хамтад нь байгуулж 1960 оны 4-р сарын 22-нд Ленины төрсөн өдөр байнгын ашиглалтанд оруулсан байна. Холбооны иж бүрэн үйлчилгээ, түүний дотор 10000 дугаарын багтаамжтай автомат телефон станцын эхний хэсэг буюу 2000 дугаарын АТС, их чадлын радио зангилгаа, радиогийн иж бүрэн студи, хот хоорондын телефон болон телеграфын станц, шуудан, цахилгаан холбооны үйлчилгээний заал бүхий / одоо байгаа/ төвийг 1960 оны намар ашиглалтанд хүлээн авсан юм.

1961 онд хуралдсан МАХН-ын ээлжит 14-р их хурал харилцаа холбоог хөгжүүлэх ойрын жилүүдийн зорилтыг . "... бүх төрлийн холбоог улам хөгжүүлэх, ялангуяа аймгийн төвийг хөдөө аж ахуйн бүх нэгжүүдтэй телефон буюу радио харилцаатай болгох, хөдөөгийн ард иргэдийг радиожуулах зорилтыг шийдвэрлэх нь чухал байна" гэж тодорхойлж уг зорилтыг хэрэгжүүлэх тодорхой арга хэмжээг улс ардын аж ахуй соёлыг хөгжүүлэх III таван жилийн төлөвлөгөөнд тусгуулан шийдвэрлэсэн байна. Эдгээр зорилтын хүрээнд манай орны сум нэгдэл, суурин газруудыг аймгийн төвтэй харилцах орчин үеийн холбооны хэрэгслээр үндсэнд нь хангасны зэрэгцээ Телефон станцын тоо 1965 онд 1960 оныхоос 86 хувь, багтаамж нь 2,4 дахин нэмэгдэж манай улсын хэмжээгээр их бага багтаамжийн нийлсэн 32 телефон станцын 83 % -ийг автомат станцаар солилоо. Телефон цэгийн тоо 1960 оноос 2,2 дахин өсч 100 хүнд 1,2 телефон цэг оногдох болжээ. Улаанбаатар хотын автомат телефон станцын багтаамжийг 4000 дугаарт хүргэлээ. Хотын телефон станцын тоо, багтаамж нэмэгдэж, мөн автомат станцийн эзлэх хувь болон кабель шугамын, хэмжээ өссөн байлаа. Хот хоорондын болон

аймаг сумын телефон яриа тус бүр 2,0 дахин өсч 100 хүнд ногдох яриа 6 минут болсон байна. Улаанбаатар -Чойбалсан, Улаанбаатар - Цагаан – Олом хүртлэх өнгөт шугамыг гурван суваг, Улаанбаатар - Сэлэнгэ чиглэлийн өнгөт шугамыг арван хоёр сувгийн системээр, Улаанбаатар - Зуунмод хоорондох шугамыг 3+1 сувгаар тус тус нягтруулсан юм. Орон нутгийг радио холбоотой болгох зорилтын дагуу (говийн аймгуудын сумдыг эхний ээлжинд РС-25 радио станцаар холбоожуулах ажлыг эхэлж) нийтдээ 130 гаруй сумыг хамруулсан байна. 1960 онтой харьцуулахад радио станцын тоо 7.5 дахин, радио зангилгааны тоо 5 дахин, радио хүлээн авагч 4.5 дахин, радио цэг 64 хувь тус тус өссөн байна.

1965 оны 8-р сарын 20-ний өдөр БНСЧСУ-ын техник эдийн засгийн тусламжтайгаар Баян -Өлгий аймгийн нутагт байгуулсан радио нэвтрүүлэх болон хүлээн авах станцууд, холбооны иж бүрэн барилгын эхний ээлжийг байнгын ашиглалтанд хүлээн авсан явдал манай орны хамгийн холын хязгаар нутаг том радио төвтэй болсон билээ.

1961-1965 онуудад шуудангийн салбарын тоо 64,7 хувь, шуудангийн хайрцаг 2,7 хувь, гарах энгийн захидал 2,6 дахин, баталгаатай захидал 80%, боодол 64,0 хувь, тогтмол хэвлэл 20.0 хувиар өсчээ. Шууданг төмөр зам, нисэх онгоцоор 7 хоногт гурван удаа, аймаг сумдын хооронд автомашинаар 2-3 удаа, ХАА-н нэгдэл, сангийн аж ахуйн тасаг фермд ердийн хөсгөөр 7 хоногт хоёр удаа тус тус хүргэдэг болсон байна.

Цахилгаан мэдээ 1965 онд 1960 оноос 2.7 дахин өсч нэг айл 2 цахилгаан бичдэг болсон байна. Харилцаа холбооны салбарт энэ 5 жилд 69.1 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын ажил хийгдэж, орлогын төлөвлөгөөг 2% буюу 3.4 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн билээ. Ийнхүү III таван жилийн төлөвлөгөөнд харилцаа холбооны талаар тө дэвшүүлсэн зорилт амжилттай хэрэгжсэн юм.

МАХН-ын 15-р их хурал “ Орчин үеийн холбоог хэлбэрэлтгүй хөгжүүлэх, харилцаа холбооны байгууллагыг зохион байгуулалт аж ахуйн талаар бэхжүүлэх, тэдгээрийн техник хангамжийг сайжруулж, хүн амыг боловсон үйлчлэх явдлыг дээшлүүлэх,

холбооны бүх талын үйлчилгээг соёлч боловсон шуурхай болгох" гэж харилцаа холбооны салбарын ойрын таван жилийн зорилтыг тодорхойлсон юм.

Түүнээс хойш удалгүй 1966 оны хавар ЗХУ-ын Холбооны яамны сайд Н.Д.Псурцев Монгол улсын холбооны яамны сайд Д.Готов тэргүүтэй төлөөлөгчдийг хүлээн авч манай орны харилцаа холбооны өнөөгийн байдал, төлөвлөж бодож байгаа асуудал, дэмжлэг туслалцаа авах чиглэл саналыг анхааралтай сонсон эдгээр саналыг хэрэгжүүлэхэд бүх талаар дэмжиж туслах үүргийг холбогдох байгууллага албан тушаалтнуддаа өгсөн билээ. Энэ уулзалтаас хойш манай орны харилцаа холбооны салбарт хийгдсэн техникийн шинэчлэл бүгдээрээ ЗХУ-ын техник эдийн засгийн дэмжлэг туслалцаатайгаар хэрэгжсэн түүхтэй билээ.

1966 оны 3-р сард Монголын үндэсний телевизийн станцыг байгуулахаар суурь тавьж ганцхан жилийн дараа 1967 оны 9 дүгээр сарын 27-нд ашиглалтанд хүлээлгэн өгөх ёслолын ажилагаанд Ю. Цэдэнбал, Ж. Самбуу, С. Лувсан, Д. Моломжамц, Н. Лувсанравдан, БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн орлогч дарга Д. Гомбожав нар яам тусгай газрын сайд, дарга нар, нийслэлийн удирдлагууд оролцож, Ю.Цэдэнбал дарга нээлтийн туузыг хайчилсан түүхтэй юм. Үндэсний телевизтэй болсон явдал манай орны иргэд хөдөлмөрчдийн улс төр, соёл, шинжлэх ухаан, техникийн мэдлэг боловсролыг дээшлүүлэх асар их ач холбогдол авчирсан билээ. Ингэснээр телевиз монголын ард түмэн, олон нийтийн өдөр тутмын амьдралын зайлшгүй хэрэгцээ болж өргөжсөн билээ. Монголын үндэсний телевизийн нэвтрүүлгээс гадна олон улсын түүний дотор хөрш ЗХУ-ын телевизийн нэвтрүүлгийг хүлээн авах боломжийг бүрдүүлэх үүднээс сансарын холбооны Орбит хэмээх хүлээн авах газрын станцыг мөн л зөвлөлт нөхдийн тусламжтайгаар байгуулж, 1970 оны нэгдүгээр сарын 31 -нд ашиглалтанд оруулсан билээ. Үүнээс гадна ЗХУ-ын үндэсний телевизийн нэвтрүүлгийг Экран системээр аймгуудын төв, сумдад үзүүлдэг болсон юм. Ингэснээр манай орны иргэд хөдөлмөрчид өөрийн орны телевизийн программын нэвтрүүлгээс гадна ЗХУ болон Европын социалист орнуудын телевизийн нэвтрүүлгийг үзэж, тэдгээр орнуудын ахуй амьдрал, соёл боловсрол, хөгжил дэвшилтэй байнга танилцах өргөн боломж бүрдсэн юм.

1966-1970 онууд нь харилцаа холбооны салбарын хөгжилд шинэ алхам хийсэн хамгийн бүтээлч, бүтээн байгуулалтын он жилүүдийн туйл нь байлаа. Яам

байгуулагдсан явдал холбоочдын идэвхи санаачлага, ажлын эрч хүчийг хэд дахинаар өрнүүлсэн юм. Үүний нэг тод жишээ нь 1967 оны 12-р сарын 16-нд эхэлсэн Холбоочдын улсын зөвлөлгөөн бөгөөд манай орны бүх нутаг дэвсгэрийн холбооны байгуулагуудыг төлөөлсөн 300 гаруй холбоочин хүрэлцэн ирж, Ардын их хурлын танхимд хуран чуулсан бөгөөд тэр үеийн нам төрийн удирдлага - Ю. Цэдэнбал, Ж.Самбуу, Д.Моломжамц, Н.Жагварал нар, БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн орлогч дарга Т.Рагчаа.Б.Дүгэрсүрэн, БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга Ц.Готов, нийслэл хотын удирдлага, Яам, тусгай газруудын сайд, дарга нар зөвлөлгөөний нээлтэнд оролцсон явдал холбооны салбарын ач холбогдолыг өндөр үнэлж, хүлээн зөвшөөрсөөний баталгаа байлаа. Зөвлөлгөөнд МАХН-ын Төв хороо, БНМАУ-ын СнЗ-өөс ирүүлсэн илгээлтэнд тус салбарын гүйцэтгэсэн үүрэг, ач холбогдлыг тэмдэглэхийн зэрэгцээ холбооны салбар, түүний дотор холбоочдын өмнө тулгарч байгаа зорилт, шийдвэрлэх асуудлуудын талаар дэлгэрэнгүй зааж өгсөн бөгөөд зөвлөлгөөн сайд Д.Готовын илтгэлийг хэлэлцэж ойрын жилүүдийн зорилтыг хэрэгжүүлэх асуудлыг хөндөж нийт холбоочиддоо хандан олон олон шинэ санаа бүхий уриалга гаргасан юм. Түүнээс хойш 10 жилийн дараа буюу 1976 оны 3-р сард БНМАУ-ын СнЗ-ийн дарга Ж.Батмөнх холбооны яамны удирдах ажилтнуудыг хүлээн авч уулзах үедээ уриалгын биелэлтийг дүгнэж үзэхэд уг уриалга үнэхээр олон жилийн хараатай чамбай хийгдсэн байсан нь мэдрэгдсэн бөгөөд хоёр заалтыг цаашид үргэлжлүүлэн хэрэгжүүлэх шаардлагатай байна гэж үзсэн юм. Мөн үндэсний телевизийн программ дамжуулах- Телевизийн станц анх удаа шинээр байгуулж байгаатай холбогдуулан 1967 оны 8-р сард БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн шийдвэрээр Телевиз, радиогийн засварын газар, Телевиз, радио өргөн нэвтрүүлгийн станцуудын техник ашиглалтын төвийг байгуулж, мөн оны 6-р сард ХАА-н нэгдэл, сангийн аж ахуйн тасаг. бригад, фермийг холбоожуулах тухай БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн тогтоол гаргууллаа. Энэхүү тогтоолоор олон чухал асуудлыг шийдвэрлэсний дотор хөдөө аж ахуйн нэгдэл, сангийн аж ахуй, мал аж ахуйн машинт станцын тасаг. бригад, фермийн холбоожуулалтын болон зарим төхөөрөмжийг угсрах жижиг ажлын зураг төсвийг цаг тухайд нь хийлгэж байх зорилгоор Хот, орон нутгийн радиожуулалтын захиргаанд зураг төсвийн групп

байгуулж, уг группийн хийсэн зураг, төсвийг баталж байхыг Холбооны яаманд үүрэг болгосон юм. Мөн хөдөө аж ахуйн нэгдэл, сангийн аж ахуй, мал аж ахуйн машинт станцын тасаг, бригад, фермийн холбоонд зориулан нэг загварын угсармал байшинг Хөдөө аж ахуйн яам, Сангийн аж ахуйнуудыг удирдах газрын захиалгын дагуу жилийн төлөвлөгөөнд тусган үйлдвэрлэж байхыг Барилгын материал үйлдвэрийн яаманд, 1967 оны 6-р сараас эхлэн авто механизмын бааз байгуулахыг манай яаманд, авто баазад шаардагдах жолооч, мэргэжилтэн, сэлбэг тоног төхөөрөмжөөр туслахыг Тээврийн хороонд тус тус үүрэг болгож шугамын мод бусад материал бэлтгэхэд зориулж төсвийн санхүүжилтийн 50 хүртэлх хувийг урьдчилан олгож байх, хөдөө аж ахуйн нэгдлийн бригадыг холбоожуулахад зориулж урт хугацааны зээл олгож байхаар тогтоосон билээ . Түүнчлэн шугамын бригадыг хөдөө ажиллах хугацаанд тухайн нутаг дэвсгэрийн АДХГ-наас мах, сүү, ногоо болон хүнсний бүтээгдэхүүнээр хангаж байх шийдвэрийг БНМАУ-ын Сайд нарын Зөвлөл 1968 онд 145-р тогтоол гарган шийдвэрлэсэн учиртай. Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн нэгжийн холбоожуулалтын талаар авах арга хэмжээ цаашид ч үргэлжилж, 1972 онд БНМАУ-ын Сайд нарын зөвлөл 498 дугаар тогтоол гарган Хөдөө аж ахуйн нэгдэл, сангийн аж ахуйн тасаг, ферм, бригадын холбоожуулалтын захиалагчаар Хөдөө аж ахуйн яам, гүйцэтгэгчээр Холбооны яам байхаар тогтоож, ХАА-н үйлдвэрлэлийн нэгжийг холбоожуулах, санхүүжүүлэх зарчим. нэгжийн холбооны ашиглалтын дүрэм, үйлчлэх журмуудыг нэг мөр болгон баталсан нь чухал үр дүнтэй шийдвэр байлаа. Агаарын шугамын барилга байгууламжийн ажлын цар хүрээ өсөн нэмэгдэж түүнд үйлчлэх авто машины хэрэгцээ нэмэгдэж байгаатай уялдуулан 1967 оны 7-р сард автомеханизмын бааз, аймгийн төв, хөдөө орон нутагт барих иргэний барилга байгууламжийн хэмжээ өсч байгааг харгалзан мөн оны 8-р сард барилга засвар. угсралтын контор байгууллаа. Мөн шинэ шугам сүлжээ техник, тоног төхөөрөмж үлэмж хэмжээгээр ашиглалтанд хүлээн авах болсоныг үндэслэн МУИС-ийн дэргэд холбооны инженерийн анги нээлээ.Хэдийгээр ЗХУ-ын Москва, Ленинград, Одесс, Новосибирск хот болон бусад орнуудад бэлтгэж байсан ч боловсон хүчин хүрэлцэхгүй байлаа. Холбооны байгууллагуудыг аж ахуй зохион байгуулалтын хувьд бэхжүүлэх тухай төр засгаас дэвшүүлсэн- зорилт. заалтын хүрээнд. холбооны шугам сүлжээг барьж байгуулах ,

/засварлах ажлыг механикжуулах. авто тээврийн үйлчилгээг сайжруулах зорилгоор автомеханизмын бааз байгуулах, шугамын нүх ухах, багана босгох зориулалт бүхий автомашинаар хангах, шугамын явуулын бригадыг вагон чиргүүлтэй болгох, үүний үр дүнд засварчин, шугамчдын хөдөлмөрийг хөнгөвчлөх. бүтээмжийг нэмэгдүүлэх зэрэг тодорхой арга хэмжээ авч эхзлээ. Тэр үед манай орны цахилгаан холбооны сүлжээний гол магистраль нь агаарын баганат шугам байсан билээ. Агаарын шугамын модыг төмөр хөлтэй болгосноор ажиллах хугацааг хэд дахин нэмэгдүүлэх санаачлагыг сайд асан М.Чимиддорж гуай анх удаа санаачлан эхлүүлсэнийг заавал үргэлжлүүлэх нь зүйтэй гэж. үзэн бетон болон бетон хөл хийх шаардлага гаран юм. Мөн түүнчлэн агаарын шугамын стандартыг анх удаа өөрийн нөхцөлдөө тааруулан баталж, төмөр буюу бетон хөлгүйгээр шугам байгуулахыг зогсоосон юм. Өөрсдийн хүчээр шугамын бетон хөл, кабелийн худаг, яндан хийх зорилгоор бетон хийцийн цех байгууллаа. Бас тодорхой хэмжээний барилга, ялангуяа өсгөх буудлын болон дизель генераторын байр, холбоочдын орон сууцыг өөрсдөө барих бэлтгэл хийсэн билээ. Холбооны салбарын эдийн засаг, чанарын үзүүлэлтийг социалист орнуудын хэмжээнд хүртэл сайжруулах буюу ойртуулах, хөдөлмөрийг шинжлэх ухааны үндэстэй зохион байгуулах, техникийн дэвшилттэй норм нэвтрүүлэх. инженер техникийн ажилтан, тэргүүний холбоочдоос гаргасан шинэ бүтээл. оновчтой саналуудыг үйлдвэрлэлд нэвтрүүлэх, эрдэм шинжилгээ, сорилт туршилт, зохион бүтээх боловсруулалтын ажлыг эрхлэх зорилгоор аж ахуйн тооцооны үндсэн дээр ажилладаг Холбооны үйлдвэрлэл шинжилгээний институтыг байгуулсан юм.

Холбооны техник төөхөөрөмж, шугам сүлжээ, байгууламжийн талаар гарч байгаа шинэ бүтээл, оновчтой саналыг судлан дүгнэж техник-эдийн засгийн үндэслэл гаргах, улс ардын аж ахуйд ашигтай шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэх технологи боловсруулах. стандарт, техникийн баримт, бичгийн загварыг гаргах; Радио долгионы тархалт. агаарын шугамын нягтруулга зэрэг чухал асуудлаар шинжилгээний ажил явуулахын хамт холбооны техник төөхөөрөмжинд сорилт, шалгалт хийж, зөвлөмж гаргах; Үйлдвэрлэл, үйлчилгээнд хөдөлмөрийг шинжлэх ухааны үндэстэй зохион байгуулах, техник ашиглалт, засвар үйлчилгээний болон материал зарцуулалтын норм, норматив боловсруулах, Холбооны талаар гадаад

оронд гарч байгаа шинжлэх ухааны ололт, тэргүүний техник, технологийг судалж, тэдгээрийг еерийн оронд хэрэглэн, холбооны үр ашгийг дээшлүүлэх үндсэн дээр холбооны салбарын хэтийн төлөвийг тодорхойлох, шинжлэх ухаан, техникийн болон шинэ санаачилга, тэргүүний туршлагын мэдээлэл, суртал нэвтрүүлгийн ажлыг зохион байгуулах; Холбооны шугам сүлжээний байгууламж, техник төхөөрөмжийн угсралт болон их засварын зураг, төсөв зохиох; Шинэ санаачилга, тэргүүний туршлагыг үйлдвэрлэл үйлчилгээнд нэвтрүүлэх төлөвлөгөө гаргаж, хэрэгжилтэнд хяналт тавих зэрэг үүргүүдийг уг институтэд хариуцуулсан юм.

1967 оны 7-р сарын 26-наас 8-р сарын 3-ны өдрүүдэд БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн дарга Ю.Цэдэнбалын урилгаар ЗХУ-ын Холбооны яамны сайд Н.Д. Псурцев манай эх оронд албан ёсны айлчлал хийж БНМАУ-ЗСБНХУ-ын хооронд харилцаа холбооны талаар хамтран ажиллах хэлэлцээрт гарын үсэг зурсан юм. Энэхүү хэлэлцээрийг БНМАУ-ын СнЗ.Сангийн яамнаас өгсөн чиглэл удирдамжийн дагуу 1966 оны 9-р сард Москва хотноо (нэг асуудлаас бусдыг) урьдчилан тохиролцож гарын үсэг зурахад бэлэн болгосон байлаа. Н.Д. Псурцевийг МАХН-ын Төв Хорооны 1 -р нарийн бичгийн дарга, БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн дарга Ю.Цэдэнбал хүлээн авч уулзаж ярилцсан бөгөөд БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдийн дарга Ж.Самбуу хүлээн авч манай төрийн дээд шагнал гардуулсан юм. Н.Д. Псурцев сайдын айлчлалын үеэр хонхорын радио нэвтрүүлэх станцын хүч чадлыг нэмэгдүүлэх, шинээр 1000 киловатт хүртэл хүч чадалтай станц байгуулах, сансрын холбооны газрын станц барих, телевизийн төвд ФМ станц нэмж суурьлуулах, Монгол улсын харилцаа холбоог 1990 он хүртэл хөгжүүлэх ерөнхий схемийг боловсруулахад дэмжлэг авах зэрэг асуудлуудыг харилцан тохирч улмаар хэрэгжүүлэх арга хэмжээг эхлүүлсэн юм.

IV таван жилд холбооны салбарын материал техникийн баазыг өргөжүүлэн хөгжүүлэхэд зориулан 62.8 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн бөгөөд холбооны байгууллагуудын үндсэн фонд нэмэгдэж, фонд өгөмж. ашигт ажиллагаа нь дээшилж. эдийн засгийн үзүүлэлтүүд сайжирсан дүн гарч байлаа.

Холбооны нийт бүтээгдэхүүний хэмжээ 1970 онд 1965 оныхоос 6.0 хувь, хөдөлмөрийн бүтээмж 14,5 хувь тус тус өсч салбар бүхэлдээ ашигтай ажилладаг болж холбооны байгууллагуудын эдийн засгийн хүч чадал нэмэгдсэн юм.

Увс, Өмнөговь. Өвөрхангай, Баянхонгор, Ховд. Хэнтий, Дорноговь, Сүхбаатар, Говь - Алтай. Дундговь зэрэг 10 гаруй аймагт тухайн цаг үеийнхээ хамгийн шилдэг технологиор тоноглогдсон. үйлчилгээний танхим бүхий 2-3 давхар барилга бариулж ашиглалтанд оруулсны зэрэгцээ олон арван сумын салбарын барилгыг өргөтгөн засварласан юм.

IV таван жилд аймгуудын холбооны газрын материаллаг баазыг бэхжүүлж, хот хоорондын болон хотын телефон холбоог хөгжүүлэх талаар тодорхой амжилт гаргасан он жилүүд байлаа.Энэ хугацаанд Даланзадгад (1966), Цэцэрлэг. Улаангом, Өндөрхаан (1967), Арвайхээр (1968), Булган Сайншанд (1969). Баянхонгор. Алтай, Тосонцэнгэл (1970), Мандалговь (1971) зэрэг нийтдээ 11 аймгийн төвийн гар телефон станцуудыг 400-500 дугаарын алхамын болон координатын автомат телефон станцаар сольж, технологийн шинэчлэлтийг үргэлжлүүлснээр бүх аймгийн төв автомат телефон станцтай боллоо. ЗХУ-ын техникийн тусламжтайгаар Дархан хотын холбооны газарт 2000 дугаарын автомат телефон станц, 12 сувгийн төхөөрөмж, тохилог үйлчилгээний заал бүхий иж бүрэн тоноглогдсон шинэ барилга ашиглалтанд орууллаа. Нийслэлийн Найрамдлын районд 10000 дугаарын багаамж бүхий АТСКУ маркийн шинэ станцын эхний ээлжийн 2000 дугаар бүхий АТС, шинэ холбооны барилга ашиглалтанд оруулж, 1979-1980 онд 8000 дугаар хүртэл нэмэгдүүлсэн түүхтэй.

1973 онд Толгойтын станцын багтаамжийг 2000 дугаар хүргэн өргөтгөж Ажилчны районы станцыг Ардчилсан Германы 2000 дугаарын координат станцаар 1976 онд сольж сайжруулсан юм. 1966-1970 онуудад 60 гаруй сум суурин газарт 20-200 дугаарын автомат телефон станц шинээр тавьсан бөгөөд 1970 оныг 1965 онтой харьцуулахад автомат телефон станцын тоо багтаамж нь 68 %, цэгийн тоо 66.5 % өссөн дүн гарч байсан бол 1979 оны эцэст 43000 дугаарын багтаамж бүхий 250 гаруй телефон станцтай болсны дотор автомат станц 210 болсон байв.

Хот хоорондын телефон сувгийн тоог нэмэгдүүлэх, агаарын шугамын засвар үйлчилгээний чанарыг сайжруулах талаар томоохон алхам хийгдсэн юм. 1965-

1970 онуудад 2900 шугамд их засвар, шинэчлэн өргөтгөл хийж, 3000 гаруй км шугам шинээр байгуулж, агаарын шугамын дундын өсгөх буудлын 20 барилгыг барьж тоног төхөөрөмжийг суурилуулан ашиглалтанд оруулсан байна.

Энэ үеэс эхлэн манай үндэсний мэргэжилтэн инженерүүд бие даан АТС, Хот хоорондын тоног төхөөрөмжөө угсарч, тохируулга хийдэг болцгоосон юм . Улаанбаатар - Ховд, Увс, Баян-Өлгий. Дорнод чиглэлийн агаарын өнгөт шугамуудыг 12 суваг, Улаанбаатар- Булган, Хөвсгөл аймгийн чиглэлийн шугамыг 15 суваг, Дундговь - Өмнөговь чиглэлийн шугамыг 3-12 сувгийн өндөр үелзлэлийн аппаратаар нягтруулсан түүхтэй. Агаарын ган шугамыг өнгөт шугамаар сольж, тэдгээрийг 15 хүртэл сувгийн системээр нягтруулах ажлыг дараахь он дарааллаар гүйцэтгэсэн юм.Улаанбаатар-Лүн-Дашинчилэн (1965), Улиастай-Загастайн даваа, Тэлмэн-Тосонцэнгэл, Нисэх-Био үйлдвэр(1966), Улаангом-Гашууны гол, Малчин-Хяргас (1967). Хяргас-Цагаанхайрхан-Баруунтуруун-Харцагаан-Ус (1968), Тэс-Баян-Уул, Баянхайрхан-Түдэвтэй-Сонгино-Сантмаргац-Цэцэн-Уул (1969), Өндөрхаан-Бэрх, Батноров-Норовлин (1970), Дархан-Сүхбаатар, Ерөө-Бугант (1971), чиглэлийн шугамуудыг байгуулж нягтруулсан юм.

1970 оны ажлын үр дүнг 1965 оныхтой харьцуулахад шугамын урт 16,6 хувь, суваг/километрийн хэмжээ 4 дахин нэмэгдэж. бүх аймгийн төвөөс нийслэл Улаанбаатар хоттой 24 цагийн турш байнгын телефон харилцаатай болгосон явдал цагийн хуваариар ээлж дараатай хүлээгдэж чирэгдэл сааталтай харилцдаг байсан бэрхшээлийг бүрэн арилгаж, манай хот хоорондын телефон холбоонд техникийн шннэчлэлт төдийгүй чанарын шинэ шатанд гаргаж чадсаны баталгаа мөн билээ. 1970 оныг 1965 онтой харьцуулахад хот хоорондын телефон ярианы хэмжээ 86,0 хувиар өссөн дүн гарч байлаа. IV таван жилд хөдөө аж ахуйн нэгдэл, сангийн аж ахуйн 149 тасаг, бригадыг утсан холбоотой, 32 бригадыг радио холбоотой болгосон юм.

Телефоны сувгаар радиогийн программыг аймгуудад хүргүүлэх алхамыг эхэлсэн бөгөөд сумдын радио зангилгааны зай тэжээлийн хангамжийг бие даан шийдэх зорилт тавьсан юм. Өөрөөр хэлбэл, сум суурин газрууд эрчим хүч байхгүй буюу, дизель станцууд нь ихэвчлэн ажилладаггүй байсан учраас радио зангилгааны

есгөгчүүдийг хуурай зай, аккумулятороор ажилладаг өсгөгчүүдээр хангах шаардлага тулгарч байлаа. Бас малчдад зориулж хуурай зай тэжээл бүхий хүлээн авагчийг ЗХУ-д захиалан хийлгэн тодорхой хэмжээгээр үнийг бууруулах замаар малчдад олгуулсан юм. 1970 онд (1965 оныхтой харьцуулан үзэхэд) радио цэгийн тоо 25%, хүлээн авагч 20% тус тус есч нийт өрхийн 66% түүний дотор малчин өрхийн 64,0 % нь радио сонсдог болсон тухай мэдээ гарч байлаа.

Шуудангийн үйлчилгээний технологийг боловсронгуй болгох. шуудан солилцоо, эргэлтийг хурдасгах, үйлчилгээний цэг, салбарыг нэмэгдүүлж холбоо хэрэглэгчдэд ойртуулах талаар ихээхэн анхаарал тавьсны үр дүнд 1970 оныг 1965 оныхтой харьцуулахад шуудангийн салбар 6,6 хувь, хайрцагны тоо 84,4 хувь, энгийн захидал 24,0 хувь, боодол 3.9 хувь, илгээлт 12,2 хувь, шуудангийн орлого 71,9 хувиар тус тус есч нэг хүн 5 захидал бичиж, 2- 3 төрлийн хэвлэл захиалан авч уншдаг болж, нэг салбар дундажаар 3200 хүнд үйлчилдэг болсон байлаа. Баян-Өлгий, Баянхонгор. Булган, Говь-Алтай.Дундговь, Өвөрхангай, Өмнөговь, Завхан, Увс, Сүхбаатар, Хөвсгөл аймгууд болон Хархоринд нисэх онгоцоор 7 хоногт 3 удаа, Архангай, Дорнод, Хэнтий, Ховд, Өвөрхангайн Хужирт, Завханы Тосонцэнгэлд өдөр бүр нисэх онгоцоор шуудан тогтмол солилцдог болж, улмаар 182 сум суурин газар шууданг нисэх онгоцоор хүргэх болж, Сэлэнгэ аймгийн төв, Дархан, Зүүн, Баруун хараа-д шууданг өдөр бүр, Дорноговь аймагт 7 хоногт гурван удаа галт тэргээр шуудан тээвэрлэх болов.

Мөн авто машинаар Хэнтий, Сүхбаатар, Архангай, Өвөрхангай, Булган, Өмнөговь, Дундговь аймгуудад тогтмол шуудан солилцдог болсон юм.

Манай гадаад харилцаа эрчимтэй хөгжсөн ЗХУ, бусад социалист орнуудаас гадна, Араб, Израиль, Турк, Америк, Япон, Канад, Испани, Энэтхэг зэрэг олон орнуудтай шуудан солилцож эхэлсэн юм. 1964 онд Дэлхийн шуудангийн байгууллага, 1965 онд Олон улсын цахилгаан холбооны байгууллага, 1968 онд Интеркосмос байгууллага, 1972 онд ЭЗХТЗ-ийн хүрээнд нягт хамтран ажиллаж олон улсын хурал зөвлөлгөөнд идэвхтэй оролцдог болсон юм.

Монгол маркийг зөвхөн Унгар улсад хэвлүүлж байсныг өөрчилж, АНУ, Герман зэрэг улсад үйлдвэрлэж, улмаар алт мөнгөн марк үйлдвэрлэх ажлыг Раднаабазар санаачилж ажилласан хэрэг билээ. Чингис хааны тухай серийн марк хэвлэгдэн

гарч шуудангийн кассаар хоёр цаг худалдахад л хэдэн мянган марк зарагдаж байсан билээ.

IV таван жилд ард иргэд албан байгууллагуудаас цахилгаан мэдээ бичиж солилцох явдал 1965 оны үеийнхээс (1970 оны байдлаар) 32,0 хувь, цахилгаан мэдээний орлого 20,0 хувиар өссөн дүн гарч байлаа. 100 хүнд оногдох цахилгаан мэдээний тоо 73-д хүрсэн билээ. 1967 онд багтаан бүх аймгуудын цахилгаан мэдээний морз аппаратыг үсэг бичигч СТ аппаратаар сольсон явдал мэдээ дамжуулах хурд нэмэгдэж, үйлчилгээний чанар эрс дээшилсэн билээ.

МАХН-ын XVI их хурлын тайлан илттэлд "... Холбооны хэрэгслийг улам сайн ашиглах, шинэ техникийг үлгэр жишээчээр эзэмших, тэргүүн туршлагыг хэрэглэх, хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэх, боловсон үйлчилгээг улам бүр нэвтрүүлэх. хөрөнгө мөнгө, сэлбэг хэрэгсэл, шатах тослох материалыг ариг гамтай зарцуулах явдал... Холбооны байгууллагын нийт ажилтны зорилт болж байна..." гэж тодорхойлсон бөгөөд их хурлаас дэвшүүлсэн V таван жилийн төлөвлөгөөний удирдамжинд "Манай орны амьдралд орчин үеийн харилцаа холбоо нэн их ач холбогдолтой" болохыг онцлон зааж "...харилцаа холбоо, радио, телевизийг цээшид хөгжүүлэх, орчин үеийн техникийг үр бүтээлтэй ашиглах, төрөл бүрийн холбоогоор улс ардын аж ахуй, хүн амыг улам чанартай үйлчлэх явдлыг" чухалчлан тэмдэглэсэн юм. Энэ нь манай орны харилцаа холбоо, радио телевиз, шуудангийн улс хот хоорондын болон аймаг сумдын бүх төрлийн шугам сүлжээг нэгэн зэрэг өргөтгөн хөгжүүлж, техник төхөөрөмжийг эзэмших, ашиглах үйл ажиллагаа, техникийн ашиглалтын чанарыг сайжруулан, хүч чадлыг нь дүүрэн ашиглаж, үйлчилгээнд соёлч байдал нэвтрүүлэх замаар харилцаа холбооны чанарын үзүүлэлтийг цуцалтгүй дээшлүүлж нийгмийн хэрэгцээг хангахад чиглэсэн зорилт мөн байлаа.

Харилцаа холбооны салбарыг бүхэлд нь хөгжүүлэх 15-20 жилийн хэтийн төлөвлөгөө, радио релейны шугам байгуулах техник эдийн засгийн үндэслэл боловсруулах, холбооны нэгж- сумын салбарын үйл ажиллагааг дээд шатанд гаргах асуудал шинээр тавигдаж байсан юм. 1972 онд МАХН-ын Төв хороо, БНМАУ-ын Сайд нарын Зөвлөл ЗХУ-ын Холбооны яамны Гипросвязь институтын мэргэжилнүүд болон манай холбооны яам хамтран боловсруулсан БНМАУ-ын

харилцаа холбоог 1976-1990 онуудад хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөг сайшааж түүнийг хэрэгжүүлэх богино хугацаатай төлөвлөгөөг 5 жилээр нь гаргадаг болсон юм.

Энэхүү хэтийн төлөвлөгөөний үзэл санаа нь БНМАУ-ын харилцаа холбооны нэгдсэн сүлжээ болох агаарын зэс шугамыг радио релей, тэгш хэмт кабель, сансрын системүүдийн аль ашигтай хувилбараар бүрэн солих, өргөн уудам нутгийг бүхэлд нь радиожуулах, үндэсний телевизийн нэвтрүүлгийг сум, орон нутагт хүргэх, бүх сумын телефон холбоогоор хангах, хөдөө орон нутаг, малчдыг холбоожуулах, шуудангийн үйлчилгээгээр хангахад чиглэгдсэн байлаа. Мөн улс, хот хоорондын телефон яриаг автомат. хагас автомат холболтонд үе шаттай шилжүүлэх, хотын автомат алхамын телефон станцуудыг координат болон электрон автомат станцуудаар ээлж дараатай солих, кабель шугамын өргөтгөл хийх, салбарын эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх, орчин үеийн технологийн шинэчлэл хийх замаар хангахаар хэрэгжүүлж, нэгдсэн сүлжээг бүсчилсэн байдлаар зохион байгуулах, олон улсын болон дотоодын дохиолол, дуудлагын системийг дэлхийн стандартанд хүргэх зорилт дэвшүүлж тухайн үедээ хамгийн дэвшилттэй хувилбаруудыг сонгосон юм.

Улс ардын аж ахуй соёлыг хөгжүүлэх V таван жилд харилцаа холбооны талаар тавьсан зорилго амжилттай хэрэгжсэн юм. Энэ хугацаанд холбооны салбарыг хөгжүүлэхэд 42.8 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын ажил хийсэн бөгөөд 1970 онтой харьцуулахад салбарын үндсэн хөрөнгө 10.9 % өсч , аймаг сумдад нийтдээ 2500 км шугам шинээр байгуулж, 3400 км шугамд их засвар өргөтгөлийн ажил хийсэн юм. Мөн Улаанбаатар-Өндөрхаан-Дорнод, Дархан-Мөрөн-Улаангом, Өндөрхаан - Баруун-Урт, Өндөрхаан-Сайншанд, Ховд-Баян-Өлгий, Улаанбаатар-Төв, Мандалговь-Даланзадгад чиглэлийн өнгөт шугамыг 15 хүртэл сувгийн системээр нягтруулан ашиглалтанд өгсөн билээ. 1975 оны эцэст хот хоорондын болон аймаг сумдын шугамын урт 17.2 мянган км, үүнээс нягтруулсан сувгийн хэмжээ 92 мянган суваг/км -д хүрч 1971 оныхоос 1.6 дахин өссөн байдаг.

Энэ хугацаанд хотын телефон цэгийн тоо 1.3 дахин. радио цэг 26%, телевизор 60.5 %, нэмэгдсэний зэрэгцээ хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн нэгжийг холбоожуулах төлөвлөгөө амжилттай хэрэгжиж 137 нэгдэл, сангийн аж ахуйн

468 тасаг нэгж бригад холбоотой болсоны 61.5 % нь телефон холбоотой болсон байв. Агаарын шугам байгуулсан дарааллыг авч үзвэл: Улаанбаатар-Налайх-Архуст - Баяндэлгэр- Цэнхэрмандал- Жаргалтхаан(1972), Тариалан-Хонгор толгой, Сулийнхээр - Хатанбулаг (1973), Жаргалтхаан - Дэлгэрхаан-Хэрлэнбаянулаан – Жаргалтхаан -Мөрөн, Өмнөдэлгэр -Хэнтий сум, Сулийнхээр-Хангийн застав (1974), Өндөрхаан-Батширээт, Биндэр-Өндөрхаан (1975), Сайншанд-Өргөн-Эрээн, Жаргалант-Загдал-Зөөхий-Салхит-Орхонтуул, (1976), Баянхонгор-Жинст-Богд-Баянлиг-Баянговь (1977), Улаанбаатар-Өндөрхаан, Даланзадгад-Жуулчны бааз, Арвайхээр-Төгрөг (1978), Төгрөг-Гучин-Ус, Баянгол-Сант-Баян-Өндөр, Төгрөг-Баянгол, Арвайхээр-Өвдөг худаг (1979), Дархан-Цагаантолгой-Баруунбүрэн, Цагаан толгой-Энхтал, Дархан-Хонгор чиглэлүүдийг шинээр байгуулах буюу өргөтгөн сайжруулсан юм.

Ялангуяа хот хоорондын цахилгаан холбооны найдвартай ажиллагааг хангах зорилгоор тойруу холбоонууд зохион байгуулан гол шугам, аймаг сумдын шугамд өргөтгөл, их засвар хийж өндөр үелзлийн нягтруулгын төхөөрөмжөөр тоногдсон нь хот хоорондын холбооны техникийн чанарыг сайжруулан, яриа, цахилгаан мэдээний саатлыг ихээхэн хорогдуулах нөхцөлийг бүрдүүлсэн билээ.

Холбооны тоног төхөөрөмж, сүлжээний арчлалт хамгаалалт, техник эзэмших чадварыг дээшлүүлэхэд анхаарал тавьж ажилласны үр дүнд тоног төхөөрөмж, дамжуулах байгууламжид тохиолдох гэмтэл саатлын тоо хэмжээ, түүний үргэлжлэх хугацаа нь жил ирэх тутам буурсаар байлаа. Холбооны техник ашиглалтын чанарын үндсэн үзүүлэлтүүд сайжирсан юм.

БНМАУ-ын улс ардын аж ахуй соёлыг хөгжүүлэх V таван жилд болсон онцгой чухал үйл явдлуудын нэг нь 1974 оны 11-р сарын 25-26-ны өдрүүдэд ЗХУКН, Зөвлөлт Төрийн тэргүүн Л.Брежнев манай улсад албан ёсоор айлчилсан явдал бөгөөд энэ айчлалын үеэр ЗХУ-аас манай орны харилцаа холбоог хөгжүүлэхэд зориулан буцалтгүй тусламж болгон 1900 км радио релейны шугам байгуулах, Дорнод, Өмнөговь, Говь-Алтай, Хөвсгөл аймгуудын төв болон нийслэл хотод их хүчний радио өргөн нэвтрүүлгийн нэвтрүүлэх станц барьж егехээр болсон билээ. Тэр үед сонин хэвлэлд гарч байснаар буцалтгүй тусламжийн нийт өртөг 60 сая рубль буюу 500 сая төгрөгтэй тэнцэх ханштай гэж байлаа. Энэхүү буцалтгүй

тусламжийн объектууд нь манай орны харилцаа холбоог хөгжүүлэх хэтийн төлөвлөгөөнд тусгагдсан байлаа. (төлөвлөгөө ёсоор бол 1990 онд багтаан хэрэгжүүлэх жагсаалт бүхий байсан). Л.Брежневийн айлчлал Монголын холбоочдын идэвхи санаачлагыг өрнүүлж сэтгэл санааг догдлуулсан үйл явдал болсон билээ. Хамгийн гол нь ЗХУ-ын Холбооны яам, түүний бүх шатны удирдлагатай манай яамны сайдаас эхлээд орлогч сайд нар, хэлстийн дарга нар, мэргэжилтнүүд хоорондоо маш зузаан, нөхөрсөг хамтын ажиллагаа, туйлын ойр дотно харилцаатай, бас өөрийн орны болон харилцаа холбооныхоо талаар хийж гүйцэтгэх ажлаа гүнзгий сайн судалж, сайн мэддэг, судалгаа тооцоо зөв бодит, манай мэргэжилтнүүд орос хэл сайн мэддэг учраас зөвлөлтийн нөхдүүдтэй саадгүй харилцан ойлголцдог байсны ач тус гарсан юм. ЭЗХТЗ-ийн дэргэдэх Нарийн бичгийн дарга нарын газрын Шуудан цахилгаан холбооны байнгын комиссын ажиллагаанд манай яамны төлөөлөгч туйлын идэвхтэй оролцож, мэргэжилтнүүдийн зөвлөлгөөнөөс эхлээд байнгын төлөөлөгчийн орлогч, байнгын төлөөлөгчийн бүх хуралдаанд асуудлаа цаг алдалгүй тавьж, ах дүү орнуудын анхаарлыг татаж байсны дотор ЗХУ-ын Холбооны яамны ЭЗХТЗ дахь байнгын төлөөлөгчийн тэргүүн, сайд Н.Д.Псурцев өөрөө их анхаарал тавьж улмаар ЗХУ-ын Засгийн газар дэмжсэн учир энэ их хөрөнгийн буцалтгүй тусламж авсан гэж бид ойлгодог юм.

Айлчлалын дараагаар тусламжийг хэрэгжүүлэхэд монголын талаас авах арга хэмжээ, шийдвэрлэх асуудлыг нарийвчлан боловсруулах ажлын хэсэг зохион байгуулсаны зэрэгцээ Зөвлөлтийн нөхдүүдтэй харилцан тохирч манай талаас ямар ажил хийж болохыг тогтоож, монголын ажилчид, мэргэжилтнүүдийг техникийн нөхцөл боловсруулах, хайгуул хийх, зураг төсөл боловсруулах болон барьж байгуулах ажилд татан оролцуулж, улмаар хөрөнгө хэмнэж Холбооны барилга монтажийн газрын материаллаг баазыг бэхжүүлэх замаар холбооны үйлдвэрлэлийн баазтай болох зэрэг асуудлыг шийдвэрлэсэн юм. Тухайлбал: манай мэргэжилтнүүд 1975 оноос эхлэн техникийн нөхцөл боловсруулж батлуулах, хайгуул хийх, цаг уур, газарзүйн холбогдолтой шаардагдах мэдээ судалгаа, өгөгдөл гаргуулах, зураг төсөл зохиох ажилд 3 жил гаруй хугацаанд байнга ажиллаж 1978 оны 1-р сарын 15-нд Төв аймгийн Баянцог сумын өмнөх уулан дээр

радио релейны шугамын анхны суурь тавих анхны ёслол болж МАХН-ын Төв хорооны Улс төрийн товчооны гишүүд, Сайд нарын Зөвлөлийн орлогч дарга нар, яам, тусгай газрын сайд дарга нар болон Төв аймгийн хеделмөрчдийн төлөөлөгчид, ЗХУ-аас БНМАУ-д суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайд, зөвлөлтийн холбооны яамны барилга угсралтын трестийн төлөөлөгчид оролцсон юм.

Мөн 1970 оны дундуур Эрдэнэтийн овооны зэс молибдены үйлдвэр барих ажил эхлэх болсонтой уялдуулан Уулын баяжуулах үйлдвэрийг барьж буй Зөвлөлтийн барилгын байгууллага болон Ашиглалтын өмнөх захиргааг ЗХУ-ын нийслэл Москва болон бусад хотууд, БНМАУ-ын Засгийн газар, яамдуудтай телефон, телеграфын холбоог шуурхай хангах үүргийг МАХН-ын Төв Хорооноос авч, холбогдох арга хэмжээг яаралтай боловсруулсан юм. Энэ арга хэмжээний хүрээнд эхний ээлжинд Дархан-Эрдэнэт чиглэлийн агаарын өнгөт шугамыг 15 сувгаар нягтруулах, Эрдэнэт-Дарханы төмөр замын дагуухи агаарын шугамаас Сэлэнгийн Орхонтуул-Улаанбаатар хүртэл нэмж агаарын шугам байгуулан шинээр нягтруулгын систем тавьж, нийслэлээс Эрдэнэт чиглэлд 15 суваг үүсгэх, Монгол дахь Зөвлөлтийн армийн Улаан-Үүдээс Дархан хүртлэх тэгш хэмт- коаксиаль кабелийг 60 сувгаар нягтруулж Эрдэнэт чиглэлд 15 суваг гаргах ажлыг жил гаруй хугацаанд, мөн Эрдэнэт-Москва, Эрдэнэт-Улаанбаатар, Эрдэнэт-Дархан, Улаанбаатар-Москва чиглэлд улс хот хоорондын хагас автомат телефон станц байгуулах ажлыг 1975-1976 онд багтаан тус тус гүйцэтгэж Дашинчилэн-Булган-Эрдэнэт чиглэлд радио релейны шугам байгуулах ажлыг 1976 оноос эхлүүлж 1979 онд ашиглалтанд оруулсан юм. Энэ таван жилийн хугацанд нийслэлийн АТС-ын багтаамжийг 4500 дугаараар, Хөвсгөл, Архангай, Өвөрхангай, Баянхонгор аймгуудын АТС-ыг 1000 хүртэл дугаар тус тус өргөтгөжээ. Телефон станцын багтаамж 124.8 % өсч, телефон цэгийн тоо 39.8 мянга болож 1975 оныхоос 28.4% нэмэгдсэн юм.

Хот хоорондын болон аймаг сумдын хооронд дахь агаарын шугамыг төмөр бетон хөлөөр бэхжүүлэх арга хэмжээг эрчимтэй үргэлжлүүлж, нийтдээ 3718.4 км шугам шинээр байгуулж, 3-15 сувгийн төхөөрөмжөөр нягтруулснаар сувгийн уртыг 3875 суваг/км-ээр нэмэгдүүлж, Улаанбаатар-Өндөрхаан, Улаанбаатар-

Даланзадгад, Улаанбаатар-Эрдэнэт, Зуунмод-Баянчандмань, Дархан-Сэлэнгэ, Сайншанд-Өндөрхаан, Сайншанд-Өмнөговь чиглэлийн шугам, гол магистралийг 12-15сувгаар, Чойбалсан-Сүмбэр, Баянхонгор-Баянлиг, Мөрөн-Шинэ-идэр, Өмнөговь-Цогтцэций-Баяновоо, Улаанбаатар-Багануур чиглэлийн шугамыг гурван сувгаар нэмж нягтруулсан юм. ХАА-н нэгдэл, САА-н тасаг фермийг холбоожуулах талаар VI таван жилд тавьсан зорилтыг амжилттай хэрэгжүүлж 70% -ийг холбоожуулсны дотор 383 нь телефон холбоотой болсон орон нутгийн холбооны салбарын 20 барилга шинээр барьж ашиглалтанд оруулан Төв, Сэлэнгэ, Архангай, Эрдэнэтийн холбооны газруудын шинэ барилгын ажлыг эхлүүлсэн билээ. Бүх суманд Экран ЧМ -телевизийн дахин дамжуулах станцуудыг ашиглалтанд еглөө. VI таван жилийн эцэс буюу 1978 оноос эхлэн Улаанбаатар-Дашинчилэн-Булган-Эрдэнэт, Дашинчилэн – Арвайхээр - Баянхонгор-Алтай – Ховд – Баян - Өлгий, Улаанбаатар –Бага – нуур - Өндөрхаан-Баруун-урт-Чойбалсан, Дархан-Сэлэнгэ чиглэлийн радио релейны шугам ашглалтанд хүлээн авч улмаар 1991 онд Чойр-Мандалговь-Даланзадгад, Чойр-Сайншанд радио релейны шугамыг ашиглалтанд оруулснаар хот хоорондын телефон сувгийн тоог эрс нэмэгдүүлэх сайхан боломж олдсоны зэрэгцээ РРШ-ын 4000 км урт трассын дагуухи дундын станц дэргэд байрлах сумын салбарууд хот хоорондын нэгдсэн сүлжээнд холбогдож улмаар ярианы саатал арилж, хэмжээ нь нэмэгдсэн юм. Радио релейны шугам ашиглалтанд орсны дараа улс, хот хоорондын сувгийн тоо эрс нэмэгдэж аймаг тус бүр нийслэл хоттой наад зах нь 12-36 түүнээс дээш , аймгууд хоорондоо 12,24,36,60 хүртэл сувагтай болж нягтруулсан суваг 1989 оны эцэст 280 мянга суваг*км хүрсэн бөгөөд гадаад гарах суваг 80 хүрсэн нь улс, хот хоорондын сүлжээнд автомат холболт үүсгэх боломж бүрдүүлсэн билээ. Түүний зэрэгцээ хот улс хоорондын яриа 1988 оныг 1980 оныхтай харьцуулахад 2-2,4 дахин, цахилгаан мэдээ 20% өссөн дүн гарч байлаа. Мөн 8-р таван жилд 13 аймаг, Дархан, Эрдэнэт хот нийслэлтэй хагас автомат холболт хийдэг болсны зэрэгцээ 14 аймгийн 68 сум аймагтайгаа хагас автоматаар яриа дамжуулах болсон байна.

Энэ хугацаанд Улаанбаатар болон Чойбалсан хотуудад тус бүр 1000 кватт хүчин чадалтай радио нэвтрүүлэх станц Алтай, Мөрөн,Даланзадгад хотуудад тус бүр 150 кватт чадалтай радио нэвтрүүлэх станцуудыг ашиглалтанд хүлээн

авснаар радио сонсголын тархалт, чанар эрс сайжирсан түүхтэй бөгөөд радио хүлээн авагч 210 мянга, шугамын радио 200 мянга, телевизор 110 мянгад хүрсэн түүхтэй.

Дүгнэлт.

1.МАХН-аас авч хэрэгжүүлсэн дээрх арга хэмжээ ЗХУ-ын техник эдийн засгийн дэмжлэг туслалцаа, манай орны холбоочдын идэвх чармайлтын үр дүнд 1960-1990 онуудад тухай үеийн технологид суурьласан Харилцаа холбооны дараах нэгдсэн сүлжээ бүрэлдэн тогтсон юм.Үүнд:

- Хот хоорондын цахилгаан холбооны нэгдсэн сүлжээ
- Аймаг,хотын төвийн телефон сүлжээ
- Радио өргөн нэвтрүүлгийн нэгдсэн сүлжээ
- Шуудан харилцааны сүлжээ
- Аймаг,сум орон нутгийн холбооны сүлжээ
- Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн 1100 гаруй нэгжийг хамарсан холбоо буюу Баг-ийн холбоо

2. Харилцаа холбооны салбар аж ахуй, удирдлага зохион байгуулалтын хувьд бүрэн бэхжиж өөрийн удирдах болон мэргэжлийн боловсон хүчнээр хангагдаж хүний нөөц бэлтгэх дээд,дунд болон түгээмэл мэргэжлийн баазтай болсон.

3.Харилцаа холбооны салбарын дотроос монгол улсын хөдөлмөрийн баатар,гавьяатууд,салбарын тэргүүний ажилтнууд, таван жилийн гавшгаачид олноор төрөн гарч олон зуун холбоочид төрийн дээд шагнал хүртсэн байдаг.

4,Тус салбарын хамт олны дундаас Монгол улсын төр нийгмийн зүтгэлтэн,АИХ-ын депутат, Намын их хурлын төлөөлөгч, Яам тусгай газрын сайд дарга нар, олон нийтийн төв байгууллагын удирдах албан тушаалтан,олон улсын байгууллагад эксперт, зөвлөх, дипломатууд олноор төрөн гарсан байдаг.

5. Харилцаа холбооны салбар манай орны эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үйлсэд бодитой хувь нэмэр оруулж манай улсын тэргүүлэгч салбарын түвшинд хүрсэн бөгөөд Монгол улсын түүхэнд анх удаа салбараа хөгжүүлэх урт хугацааны төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлсэн түүхтэй.